




МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.01.08 № 1/84  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯН-ОВОО СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА Б.ОТГОНБАЯР  
ТАНАА

“Малын тоо толгойн албан татварын хэмжээнд өөрчлөлт оруулах тухай” Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 12/03 дугаар тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6537 дугаарт бүртгэж хүргүүлэв.

  
Б.ЭНХБАЯР

151605731  
Doc.yam a5.2023



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 12/03

Хөхбүрд

Малын тоо толгойн албан татварын  
хэмжээнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 12 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын малын тоо толгойн албан татварын ногдол, төлөлтыг хэлэлцээд 2023 оны малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг бууруулан тогтоосугай.

2.Малын тоо толгойн албан татварын хэмжээг малын таван төрөл тус бүр дээр 400 (дөрвөн зуун) төгрөг байхаар тогтсугай.

3.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээр дагаж мөрдсүгэй.

3.Татварын хэмжээ, ногдолыг сурталчилан таниулж, татвар төвлөрүүлэлтийг үр дүнтэй зохион байгуулахыг Засаг дарга (Г.Орхонтуул)-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо (Ц.Жаргалсайхан)-д даалгасугай.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 8/04 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Б.ОТГОНБАЯР



648801075



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 07/04

Хөхбүрд

Сумын хог хаягдлын үйлчилгээний  
хураамжийн хэмжээг шинэчлэн  
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэг,ж, түүний удирдлагын тухай хуулийн дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дах заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 7 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

- 1.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоож хавсралтаар баталсугай.
- 2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг албан байгууллага, ард иргэдэд танилцуулж, шинэчилсэн тарифаар хураамж тооцож ажиллахыг сумын Засаг дарга (Т.Бямбадорж)-д үүрэг болгосугай.
- 3.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээр дагаж мөрдсүгэй.
- 4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 10/10, 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 02/02 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
- 5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын нарийн бичгийн даргад даалгасугай.

ДАРГА  Б.ЭРДЭНЭБААТАР

642501037

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
 2025 оны 4 дугаар сарын 19-ны өдрийн  
 ээлжит 7 дугаар хуралдааны 4 дүгээр  
 тогтоолын хавсралт

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Үйлчилгээний төрлүүд	Хэмжих нэгж	Хураамж /төгрөг/
1	Төрийн болон төрийн бус байгууллагын энгийн хог хаягдал	Сар бүр	50,000
2	Уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж	Сар бүр	50,000
3	Авто угаалга, дугуй засвар	Сар бүр	20,000
4	Худалдаа үйлчилгээний газар, дэлгүүр, гуанз, бар, ресторан, хоол үйлдвэрлэлийн газар	Сар бүр	50,000
5	Ил задгай талбайд худалдааны үйл ажиллагаа эрхлэгч дэлгүүр, баяр наадмын үеэр барьсан цайны газар, бусад цэгүүд	Сар бүр	50,000
6	Хөрөө рам, модон эдлэлийн үйлдвэр, ноос эсгийн үйлдвэр	Сар бүр	20,000
7	Амралт, сувилалын байгууллагын хог хаягдал	Сар бүр	50,000
8	Шатахуун түгээх газар	Сар бүр	20,000
9	Сумын төвийн өрх /Нэг иргэний тооцооллоор/	Сар бүр	10,000
10	Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй ААНБ	Ашиглалт	Сар бүр 200,000
		Хайгуул	Сар бүр 100,000
		Бичил уурхай	Сар бүр 50,000

